



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 02 сарын 19 өдөр

Дугаар 53

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Засгийн газрын автобааз” улсын төсөвт үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 154,000,000.00 (нэг зуун тавин дөрвөн сая) төгрөгийн балансын үнэ, 107,760,644.41 (нэг зуун долоон сая долоон зуун жаран мянга зургаан зуун дөчин дөрвөн төгрөг дөчин нэгэн мөнгө) хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг Хууль сахиулахын их сургуульд балансаас балансад шилжүүлсүгэй.

2. “Засгийн газрын автобааз” улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал С.Энхбаяр, Хууль сахиулахын их сургуулийн захирал Ө.Энхтөр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ




Б.ГАНБАТ

БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

0000103



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 02 дугаар сарын 19-ны өдрийн 53.
дугаар тогтоолын хавсралт

**"Засгийн газрын автобааз" УТҮГ-ын балансаас Хууль сахиулахын их сургуулийн балансад
шилжүүлэх үндсэн хөрөнгийн жагсаалт**

д/д	Эд хөрөнгийн нэр	Ашиглалт ад орсон он	Хэм жих нэгж	Тоо шир хэг	Нэг бүрийн үнэ (төгрөгөөр)	Нийт үнэ (төгрөгөөр)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөгөөр)	Үлдэгдэл өртөг (төгрөгөөр)
1	Ланд крузейр-200 маркийн, 02-00 УБЗ улсын дугаартай, арлын дугаар - JTMHV05J505030748 суудлын автомашин	2011	ш	1	154,000,000.00	154,000,000.00	107,760,644.41	46,239,355.59
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН							
				1 (нэг)	154,000,000.00 (нэг зуун тавин дөрвөн сая)		107,760,644.41 (нэг зуун долоон сая долоон зуун жаран мянга зургаан зуун дөчин дөрвөн төгрөг дөчин нэгэн мөнгө)	46,239,355.59 (дөчин зургаан сая хоёр зуун гучин есөн мянга гурван зуун тавин таван төгрөг тавин есөн мөнгө)